

## Үйлчилгээний тасаг

Орхон аймгийн Эрүүл мэнд, ниймийн даатгалын хэлтсийн үйлчилгээний тасаг нь:

- Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай
- Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай
- Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулиудын хэрэгжилтийг ханган, иргэдэд мэдээлэл лавлагаа олгох чиг үүрэгтэйгээ.



- Тасгийн дарга-1
- Тэтгэврийн байцаагч-4
- Тэтгэмжийн байцаагч-2
- Жаргалант сумын байцаагч-1
- Сүлжээний мэргэжилтэн-1
- Сургалт сурталчилгааны мэргэжилтэн-1
- Бичиг хэрэг дотоод хяналтын ажилтан-1
- Архивын эрхлэгч-1
- Төрийн үйлчилгээний нэг цонхны байцаагч гэсэн 12 байцаагч ажилтаны бүрэлдэхүүнтэйгээр нийгмийн даатгалын үйлчилгээг иргэд даатгуулагчдад үзүүлэн ажиллаж байна.

2017 онд 1251 даатгуулагчид шинээр тэтгэвэр тогтоож, 15280 тэтгэвэр авагчид 6 банкаар дамжуулан, сард 5,3 тэрбум төгрөгийн тэтгэвэр тавьж үйлчилж байна.

Тэтгэмжийн даатгалын сангаас 10429 даатгуулагчид хуулийн дагуу тэтгэмж олгож, ажилгүйдлийн даатгалын сангаас 697 иргэнд тэтгэмж олгон эдийн засгийн эрсдлийг хуваалцан, даатгуулагчид үзүүлэх нийгмийн даатгалын үйлчилгээг түргэн шуурхай, чанар хүртээмжтэйгээр хүргэхийг зорилтоо болгон ажиллаж байна.

